

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2018 оны 03 дугаар  
сарын 15 -ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар  
хот

Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг  
байгуулах тухай

Засгийн газрын 2011 оны 323 дугаар тогтоолоор батлагдсан “Жендэрийн үндэсний хорооны дүрэм”-ийн 2.2, 2.7-д заасныг үндэслэн Хорооны хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Жендэрийн үндэсний хорооны дэргэд Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлгийг байгуулсугай.
2. Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлгийн бүрэлдэхүүн, дүрмийг батлан бүлгийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны даргад үүрэг болгосугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Жендэрийн Үндэсний шинжээч-зөвлөх бүлэг байгуулах тухай” Жендэрийн үндэсний хорооны 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,  
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ  
ДАРГА



  
У.ХҮРЭЛСҮХ